

ҮНДЭСЛЭН БАЙГУУЛАГЧ

ЧИНГИС ХААНЫ ТӨРСНИЙ 800 ЖИЛИЙН ОЙД

Маркс-ленинизм, нийгмийн хөгжилд ард түмэн шийдвэрлэгч хүчин, түүхийг бүтээгч гэж сургахын хамт гарамгай хүний ролийг үгүйсгэлгүй.

Чингис хаан бол тухайн үедээ гялалзсан зохион байгуулагч, төрийн гарамгай зүтгэлтэн, их жанжин байсан юм. Чингис хааны намтар түүх үйлдэл, бүтээл олон орны судрын хүмүүс, эрдэмтэн, шинжээчдийн сонирхол анхаарлыг татаж өдий төдий бичиг зохиол гарсан бодно.

Чингис бол 3 дугаар жарны үеийн морин жилийн зуны тэр үеийн сарын 16-ны тэргэл өдөр буюу европын 1162 оны 5 дугаар сарын 31-ний өдөр БНМАУ-ын Хэнтий аймгийн Дадал сумын нууц одоо хүртэл уул дээрээ халгалж буй Онон мөрний Дэлүүн Болдог гэдэг газар Хабуу хааны ач хүү Есөгийн баатрын гэргий Өгэлүн хатны хүү болон төржээ. Түүний жинхэнэ нэр Тэмүжин. Тэмүжиний төрөхөд Есөгий баатрын эрх мэдэл төдий л ихгүй болсон байжээ. Тэмүжин, эцгээс эрт ангижирч эх ба хэдэн дүү нарын хамт газрын үндэс хаж, тарвага зурам, загас агнах зэргээр ядуу зүдүү байдалд өсөн хүмүүжжээ. Тийм хөдөөлд Тэмүжиний төрөлтийн саруул ухаан, зориг самуун нь товойн, удалгүй нөхөд (баг цэрэг)-тэй болсон нь түүний байдлыг бэхжүүлэв.

Тэмүжин түүхийн тавцан дээр гарч ирсэн цаг нь Монгол оронд овгийн байгуулалтын эцэст байдалаар солигдох түүхийн зүй тогтоолт, дэвшилт үзэгдэл нэгэнт боловсорсон үе байв. Тэр үеийн монгол аймгуудыг талын малчин, анчин гэж хоёр хэсэгт хувааж болох бөгөөд талын малчин нь ойр иргэдийг болгох хөгжлийн хир хэмжээгээр ядуу байжээ. Талын малчин үндэс баялаг нь мал сүрьеэ бөгөөд түүнийг хувьдаа өмчлөх явдал үүсэж баялаг малчид овгийн хүрээнд элчлэн гарч айдаар нүүдэллэх явдал зонхилох болсон нь овгийн хуучин байгууллыг эвдэж феодалын ёст байдлыг тогтоохын үндэс болжээ. 12 дугаар зууны эцэст монгол оронд Хамаг монгол, Кэрэйд, Найман Татаар Мэргэд зэрэг хэд хэдэн феодалын түрүү үеийн жижиг улсууд үүсч бий болоод байсан цаг бөгөөд тэдгээрийг феодалжиж байсан талын язгууртан нар толгойлон газар нутаг, мал сүрьеэ хүн ардаа булаацалдан харш цан тэмцэлдэж байжээ. Тэр тухай «Нууц товчоонд» «Одтэй тэнгэр орчиж Слон улс байлдаж

Орондоо унтах завгүй Олзлон булаацалдаж байв. Хөрст дэлхий хөрвөж Хөвчин улс хямралдаж Хөнжилдөө унтах завгүй Хөнөөлдөн тэмцэж байв» гэж өгүүлсэн билээ.

Хэрэг явдлын энэ өрнөл нь тэдгээр феодал язгууртны дотор аль нэгэн хүч чадалтай нь товойн гарч бусдаа эрхэндээ оруулан захирах замаар шийдвэрлэгдэх ёстой байсан бөгөөд тэр тэмцлийн явцал Тэмүжин тодрон гарчээ. Тэмүжин бол феодалжиж байсан монголын язгууртны нэг бөгөөд бүх хүч чадалаа феодал язгууртан ангийн төлөө зориулсан хүн юм.

Тэмүжиний улс төрийн гарамгай эхний алхам нь өөрийн эцгийн захирч байсан аймгуудыг буцаан захираад дараа нь 1189 онд Онон, Туул, Хэрлэн гурван голын монголчуудыг нэгтгэн захирсан явдал юм. 1205 он болоход монголын гол гол том аймгуудыг Тэмүжин нэгтгэн захирах болсон байна. 1206 онд Онон мөрний хөвөөнд ноёдын их хуралтай болж бүх монголын их хаанд Тэмүжинийг өргөмжилж Чингис цол өргөжээ.

Жижиг улс аймгууд нэгдэж монголын түүхэнд анхдугаар удаа нэгдмэл улс байгуулагдсан нь Монголд феодалын ангит нийгэм үүссэний үр дүн

мөн байв. Чингис хаан тархай бутархай монгол аймгуудыг нэгтгэсний үр дүнд Монголын төрийн тусгаар тогтнолын эх суурь тавигджээ.

Чингис хааны монголын нэгдмэл улс байгуулсан түүхэн ролийг өгүүлэхийн хамт түүний хийсэн шинэтгэлүүдийг тэмдэглэх хэрэгтэй. Чингис хаан өөрийн улсын дотор цэрэг, засаг захиргааны шинэ зохион байгуулалт тогтоож, зам харилцааг тогтмол болгон уудам их орны дотор олон зүг салбарласан өртөө байгуулсан юм.

Чингисийн улсаа зассан явдлын дотор засаг захиргаа цэргийн шинэтгэл нь гол суурь эзэлнэ. Чингис хаан, нийт хүн амыг түмт, мянгат, зуут, аравт гэдэг захиргааны нэгжид оруулан, бүх улсыг зүүн, баруун гар, төв буюу голын түмэн гэдэг гурван том хэсэгт хуваажээ. Захиргааны энэ систем нь тайван цагт мал аж ахуйгаа эрхлэх ба дайны үед аравтаас эхлэн түм хүртэл цэрэг гаргах үүрэг бүхий байжээ. Үүнээс гадна Чингис, түмэн тоотой хишигтэн гэдэг бие хамгаалах, ордны шадар цэрэг байгуулжээ. Хишигтэн бол аливаа талаар онцгой эрхтэй их хааны мэдлийн торгон цэрэг бөгөөд тэдний гол үүрэг нь ард олны эсэргүүцэл тэмцлийг дарах явдал байжээ.

Чингис, бүх улсын иргэдийг ураг элгэн ба улс байгуулахад зүтгэсэн ноёдод хувиарлан өгч бүгд 95 мянгатын ноёд томилж тэдэнд албат харъяат нутаг ус олгосон тухай «Нууц товчоонд» тодорхой өгүүлжээ. Чингисийн улсын санхүүгийн байгууламж нь «гувчуур» гэдэг татвар бөгөөд оногдуулах нэгж нь хонь байжээ. Албат харъяат нар улсын их хаанаас гадна харъяалах ноёдод гувчуур төлж аж ахуйд нь зүтгэдэг байжээ.

Их хааны дэргэд цэцдийн зөвлөл гэгч байсан бөгөөд тэдний зөвлөлгөөг төрийн үйлсэд анхааран үздэг байжээ.

Шинэ хаан сонгох, байлдах, найрамдах зэрэг онцгой чухал асуудлыг «их хуралдай» гэгч бүх ноёдын чуулга наар хэлэлцэн шийдвэрлэдэг байжээ.

Чингисийн шинэтгэлийн тухай өгүүлэхдээ түүний эх үндсийг тавьсан монгол улсын төрийн цааз «Их засгийн» тухай дурдах хэрэгтэй. К. Маркс «Их засгийг» «Иргэний башшны ерөнхий хууль» гэж заасан юм. «Их засаг» нь феодалын эрх ашгийг хамгаалж харц олны эсрэг хурц үзүүрээ хандуулсан догшин хатуу хууль боловч овгийн байгууллын үлдэгдэлд мэдэгдэм цохилт өгч феодалын харилцааг хуулиар бататгасны хувьд тухайн үедээ дэвшилт зүйл байжээ.

Чингисийн үед монголчууд уйгуржин бичгийг улсын бичиг болгон авч хэрэглэсэн билээ. Улсын хэмжээгээр нэгдсэн бичигтэй болсон нь монголчуудын оюуны соёлын дэвшилтэд үлэмж тус болсон юм.

Чингис хаан бол цэргийн арга ухааны түүхэнд тэмдэглэгдсэн их жанжны нэг юм. Гэвч Чингис тэргүүтэй Монголын феодалын шинэ дугам үүсч тогтсон Монгол улсын бүхий л чадал хүчийг бусад улс түмнийг түрэмгийлэн боолчлох гэсэн цэрэг дайны ажиллагаанд чиглүүлсэн юм. Чингис 1211—1215 онд зөрчидийн Алтан улс, дараа нь Дундад Азийг байлдан эзэлснээс гадна Чингисийн цэрэг 1222-1224 онд умарт Иран, Кавказ, дорнод Европод цөмрөн орсон байна.

Чингис 1225 онд баруун зүгийн байлдаанаас буцаж ирсэн бөгөөд 1227 онд Тангу-

дын Ся улсыг байлдан эзлэхээр цэрэг авч мордоод байлдааны дундуур өвчин олж нас баржээ. Монгол тулгар бичгүүдэд Чингисийг улаагчин гахай жилийн 7 сарын 12-ны өдөр нас барсан гэжээ. Чингисийн шарилыг төрсөн эх нутагт нь оршуулжээ.

Монголын феодалуудын байлдан дагууллын амжилт нь Чингисийн цэрэг тэр үед зохион байгуулалт, сахилга бат, хэрэглэсэн зэвсэг техникээр тэргүүн зэрэг хэмжээнд байснаар тайлбарлагдахаас гадна, Чингисийн довтолгоонд эрстсэн Ази, Европын орнууд улс төрийн талаар бутархай, засгийн эрх барьсан дарлагч ангийн этгээдүүд бүхий л талаар ялзарч, хоорондын хямрал тэмцэлд идэгдэж байснаас болжээ. Байлдан довтолгочдын өмнөөс эх нутаг тусгаар тогтнолоо хамгаалан тэмцэж байсан тууштай тэмцэгчид нь гагцхүү ард түмэн байжээ.

Чингисийн байлдан дагуулал бол монголын феодалуудаас харь орныг түрэмгийлэн эзлэхээр явуулсан шударга биш харгис дайн юм. Чингисийн 20 жилийн байлдан дагууллын үршгаар түүнд эрстсэн орнуудын үй түмэн хүний амь үрэгдэж хот тосгон үнсэн товрог болж, эдийн засгийн хэвийн явц нэг хэсэг тасалдаж, үйлдвэрлэх хүчин үлэмжхэн сүйджээ. Чингис, түүний залгамжлагчдын явуулсан дээрмийн дайн Монголын хөгжилд маш хортой нөлөө үзүүлсэн юм.

Монголын феодалуудын байлдан дагууллын үеэр монгол эрчүүдийн сор нь дайнд үрэгдэж өдий төдий нь эх нутгаасаа үүрд салж харь газар оронд хоцрон үлджээ. Чингисийн гүрэн үүссэний дараа Монголын улс төр, эдийн засаг, соёлын төв нь Монгол нутгаас гадагш шилжжээ. Үүнээс үзэхэд Монголын феодалуудын дээрмийн аян дайн зөвхөн түүнд эрстсэн ард түмэнд асар их гай гамшиг болсноор зогсохгүй, монгол орны үйлдвэрлэх хүчин сулран доройтохын шалтгаан нь болсон байна. Иймд Чингис хаан бол нийгмийн түүхэнд дэвшилт роль гүйцэтгэхийн зэрэгцээгээр харгис үйлдлийг хийсэн зөрчилт үйл ажиллагаа бүхий түүхт хүний нэг юм.

Манай нам, Чингис хааны үйл ажиллагааны феодал ангийн чанар, Чингис болоод түүний залгамжлагчдын дээрмийн дайны харгис ролийг үгүйсгэх гэсэн үндсэрхэг үзлийг тухай бүрд нь шийдвэртэй эсэргүүцэн тэмцэж ирсэн юм.

Империалистууд, хятадын Чанкайшигийн харгис бүлэг Монголын түүх, ялангуяа Чингис хааны ролийг гуйвуулан завхруулах замаар манай улсын тусгаар тогтнолд заналхийлсэн түрэмгий бодлогоо элдвээр нотлохыг оролдсоор байна. Гэвч тийм оролдлогоо нь ямар ч ирээдүйгүй болох нь мэдээж хэрэг. Социалист хүчирхэг лагерийн гишүүн БНМАУ-ын түүхийн эртний уламжлалт төрийн тусгаар тогтнол нь халдашгүй дархан юм.

Чингисийн төрсний 800 жилийн ойг бид хүн төрөлхтний түүхийн цоо шинэ үе—дэлхийн социалист систем манай эрэн үеийн хөгжлийг тодорхойлж байгаа үед тэмдэглэж байна.

Чингисийн анх үндэслэн байгуулсан феодалын төрийн оронд ардын хувьсгалын ачаар энх тайван, эв найрамдал шударга ёс эрхэмлэсэн шинэ социалист Монгол улс үүсэн тогтоод 40 гаруй жил болж байна. Монголын ард түмэн нэгэн үзэл суртал, нэгэн зорилготой ах дүү социалист орнуудтай тогтоосон марксизм-ленинизм пролетарийн интернационализмын зарчим дээр үндэслэсэн эвдрэшгүй найрамдал, нэгдэл нягтралаа бэхжүүлэн хөгжүүлж эх орондоо социализм, коммунизм байгуулахаар итгэл төгс давшиж байна.

Академиц Ш. Нацагдорж